

БАТЛАВ
“ДЦС-4” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

.....
..... Г. ТӨМӨРХУЯГ /

БАТЛАВ
“ДАРХАН МЕАТ ФҮҮДС” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

.....
..... /М.ЭНХБААТАР/

**ҮХЭР ХОНЬ АДУУНЫ МАХ 2 БАГЦ
ХОНИНЫ МАХ БАГЦ 1 ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

2020 оны 6 дугаар
сарын 2 ны өдөр

№ 3/2020-330

Улаанбаатар
хот

Нийтлэг зүйл

Нэг талаас “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ыг төлөөлж Худалдан авах ажиллагааны дарга О.Гантөмөр нөгөө талаас “Дархан меат фүүдс” ХХК /цаашид “Нийлүүлэгч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Энхбаатар нар Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

- 1.1 Нийлүүлэгч нь **ХОНИНЫ МАХ БАГЦ 1** /цаашид “бараа/-ийг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох Хавсралтад заасан нэр төрөл, тоо хэмжээ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу СИП -Улаанбаатар “ДЦС-4” ТӨХК-ийн агуулах нөхцлөөр нийлүүлнэ.
- 1.2 Бараа нь стандартад нийцэж байгааг харуулсан дагалдах баримт бичгүүдтэй, биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй байна.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Гэрээний хугацаа нь талууд гарын үсэг зурснаас хойш 1 жил байна. Нийлүүлэгч нь барааг хугацаанд нь багтаан нийлүүлнэ.

Гурав. Үнэ, төлбөрийн нөхцөл

- 3.1 Энэ гэрээний нийт үнэ **414.982.920 / дөрвөн зуун арван дөрвөн сая есөн зуун наян хоёр мянга есөн зуун хорин/** төгрөг бөгөөд үнийн дүнд гааль, онцгой татвар, УБ “ДЦС-4” ТӨХК-ийн агуулах нөхцлөөр тээврийн зардал, НӨАТ бүгд шингэсэн байна.
- 3.2 Барааг нийлүүлж гэрээ дүгнэсэн акт үйлдсэний дараа хүлээн авсан барааны төлбөрийг Захиалагч Нийлүүлэгч талд 30 хоногт багтаан төлнө.
- 3.3 Захиалагч нь гэрээний үнийн гүйцэтгэлийн баримт бичгийг үндэслэн Нийлүүлэгчийн төлбөрийн нэхэмжлэлийн дагуу Нийлүүлэгчийн дансанд төлнө. 1 жилийн турш үйлчлэх гэрээнд энэ заалтыг баримтална.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа биелүүлээгүй бол нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн дүн нь гэрээний нийт үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.
- 4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсны дараах төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба гэхдээ алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.

- 4.3 Нийлүүлэгч нь гэрээг хэсэгчлэн болон бүрэн биелүүлээгүй тохиолдолд энэхүү гэрээний 4.1 ба 4.2-т заасан хариуцлагаас Нийлүүлэгчийг чөлөөлөхгүй ба түүний тендерийн гүйцэтгэлийн баталгааг хэрэгжүүлэх хангалттай үндэслэл болно.
- 4.4 Барааг “ДЦС-4” ТӨХК-ийн агуулахад ирсний дараа тус компанийн Бараа материал хүлээн авах комисс болон холбогдох цехийн ИТА нар гэрээний техникийн тодорхойлолтод заасан хэмжээнд хүрч байгааг тогтоосон тохиолдолд орлогод авна. Барааг техникийн үзүүлэлтэнд хүрээгүй тохиолдолд барааг буцаана.

Тав. Бараа, бүтээгдэхүүний чанар, сав, баглаа боодол

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол Улсын стандарт, техникийн нөхцөл хэмжээг бүрэн хангасан байна.
- 5.2 Бараа нь Захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд мөн шинж чанараа алдахгүй байх ёстой.
- 5.3 Нийлүүлсэн барааны чанарт ямар нэг дутагдал илэрвэл түүнийг засах, сольж өгөхийг Захиалагч шаардах ба Нийлүүлэгч уул шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.4 Барааны баглаа, боодол дараах байдлаар хаяглагдсан байна.
- Гэрээний дугаар
 - Цэвэр жин
 - Бохир жин
 - Барааны нэр
 - Хүлээн авагчийн хаяг
 - Ачаа илгээгч
- 5.5 Барааг дараах бичиг баримт дагалдана.
- Чанарын гэрчилгээ
 - Барааны гарал үүслийн гэрчилгээ

Зургаа. Барааг хүлээн авах

- 6.1 Нийлүүлэгч нь бараа ачигдсан тухай нотлох бичиг баримтыг бараа ачигдсанаас хойш 48 цагийн дотор мэдэгдэнэ.
- 6.2 Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын “ДЦС-4” ТӨХК-ийн агуулах нөхцлөөр илгээнэ.
- 6.3 Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртлэх тээврийн бүх зардлыг хариуцна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйлс

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчлэн буюу бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцлүүд гарч эхэлсэн тохиолдолд 10 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвлөлдөнө.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1 Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх хугацааг энэхүү гэрээнд зааснаас 30 хоногоор хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээ цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч нь уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч нь гэрээг цуцлах ба Гүйцэтгэлийн баталгааг буцаан олгохгүй.
- 8.2 Нийлүүлэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч нь энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.
- 8.3 Аль нэг тал нь зөвшөөрөлгүйгээр тус гэрээний 9.3 дахь заалтыг зөрчсөн тохиолдолд энэхүү гэрээг хугацаанаас өмнө цуцлана.

Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талууд аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээнд дур мэдэн нэмэлт өөрчлөлт оруулах, зүйл заалтыг өөрчлөхийг хориглоно.
- 9.4 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, захиалагч 2 хувь, нийлүүлэгч нэг хувийг авах бөгөөд хувиуд нь ижил тэгш хүчинтэй.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 9.6 Хуулинд заасан нөхцлөөр гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн аливаа оруулга, засвар, нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийднэ.
- Энэхүү гэрээ нь Үндсэн гэрээ 4 хуудас, Хавсралт ... хуудас, бүгд ... хуудаснаас бүрдэнэ.

Арав.Талуудын хаяг:

Захиалагч:

Банк:

Данс:

Захиалагчийн хаяг:

Баянгол дүүрэг 20-р хороо

“ДЦС-4” ТӨХК-ийн байр

Факс: 70001374

Утас: 70171284

Нийлүүлэгч:

Банк:

Данс:

РД:

Нийлүүлэгчийн хаяг:

Утас:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ,
ЕРӨНХИЙ ИРХЭНЕР
...../Б.ГАНХУЯГ/
СБХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТВАН БОЛОГЧ
...../Д.ТӨМӨРТОО/
ТЭЭХ-ИЙН ДАРГА
...../Ж.ОТГОН/
ХААХ-ИЙН ДАРГА
...../О.ГАНТӨМӨР/
ХУУДИЙН ЗӨВЛӨХ
...../Ч.БЯМБАСҮРЭН/
ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН
...../С.ДОНИД/

“ДАРХАН МЕАТ ФҮҮДС” ХХК-Н
ЗАХИРАЛ

...../М.ЭНХБААТАР/
ДАРХАН МЕАТ ФҮҮДС
ХХК
4517255120 4257284

4/2020-330

.....тоот гэрээний хавсралт №01
Хонины мах нийлүүлэх үнэ, тоо хэмжээ


Хонины мах						
№	Бүтээгдэхүүний нэр	Гарал үүслийн улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Мах хонины	Монгол	кг	55479	7,480.00	414,982,920.00
ДҮН						414,982,920.00

№	Бүтээгдэн үүний нэр	Хэмжих нэгж	Мах нийлүүлэлтийн хуваарь												Нийт дүн
			2020 оны 7 сараас						2021 оны 6 дугаар сар хүртэл						
			7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	
1	Хонины мах	тн	4,623.25	4,623.25	4,623.25	4,623.25	4,623.25	4,623.25	4,623.25	4,623.25	4,623.25	4,623.25	4,623.25	4,623.25	55,479

Жич: Махыг сард 2-3 удаа захиалах бөгөөд захиалгын дагуу махны зориулалтын хөргүүртэй машинаар авна. Захиалга өгснөөс хойш ажлын 3 хоногт багтаан нийлүүлэх

ХААХ-ийн дарга


 О.Гантөмөр

ХААХ-ийн мэргэжилтэн

 Ж.Айдос

“ДАРХАН МЕАТ ФҮҮДС” ХХК-ийн захирал

 М.Энхбаатар





.....тоот гэрээний хавсралт №02

МАХ НИЙЛҮҮЛЭГЧ КОМПАНИД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Маханд тавигдах техникийн ерөнхий шаардлага

Нийлүүлэх мах нь MNS 1111:2007 болон MNS 5023:2011 стандартын шаардлагад бүрэн нийцсэн байна

Мах нь сайтар цэвэрлэгдсэн, улаан хоолой, мөгөөрсөн хоолойг бүрэн гүйцэд авсан дотор эрхтэн, арьс, чив, төмсөг, дэлэнгийн үлдэгдэлгүй, цус, сэвс болон бусад гадны элдэв бохирдол /үс ноос, шороо, бензин тосны үнэр шингэсэн/-гүй байх ёстой. Мөн хөлдөөсөн махны гадаргууд цас мөс наалдаж хуримтлагдсан байж болохгүй.

Хүснэгт 1

Төрөл бүрийн маханд тавигдах мэдрэхүйн эрхтний үнэлгээний шаардлага

№	Махны төрөл	Үнэр	Өнгө	Гадаад байдал онцлог шинж чанар
1	Хонины мах		Улаан ягаан	Гулууз махны гадаад хэлбэр бөөрөнхий, булчин сайн хөгжсөн сээр нуруу, хондлой товойгоогүй, тэгшхэн, ташаан толгой бөөрөнхийдүү, товойгоогүй, ууц нуруу, ташаа, хонго, сүвээний орчмоор өөхний хуримтлал сайтай байна. Хонины 1 гулууз махны жин 24-30 кг-аас доошгүй байна.

Хүснэгт 2

Төрөл бүрийн махны аюулгүйн үзүүлэлт

№	Махны төрөл	Үзүүлэлт	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Стандарт
1	Үхэр, хонь, адууны мах	Хар тугалга	0,1 мг/кг	MNS5868:2008
2	Үхэр, хонь, адууны мах	Кадьми /Cd/	0.05 мг/кг	MNS5868:2008
3	Үхэр, хонь, адууны мах	Цагаан тугалга /Tin, Sn/	200 мг/кг	MNS5868:2008

Хүснэгт 3

Төрөл бүрийн махны аюулгүйн үзүүлэлт

№	Махны төрөл	Үзүүлэлт	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Стандарт
1	Үхэр, хонь, адуу, гахайн мах	Салмонелл	25гр-д илрэхгүй	MNS ISO 6579:99
		Листери моноцитогенес	25гр-д илрэхгүй	MNS ISO 11290-2:2000

Хадгалалт, тээвэрлэлт

Мах, махан бүтээгдэхүүнийг зориулалтын хөргөх төхөөрөмжинд хадгална. Хөргөсөн мах хадгалах өрөө нь +8-аас дээшгүй хэмтэй, хаалга, цонхондоо ялаа, шавьжнаас хамгаалсан тор татсан байх ёстой. Хөлдөөсөн мах хадгалах байр нь -18- -24 хэмтэй, маханд элдэв будагч, үнэр, амт шингээж болзошгүй бодис орохоос сэргийлэгдсэн байна.

- Мах, махан бүтээгдэхүүн тээвэрлэх тээврийн хэрэгслийн бүхээг, тэвшний дотор талыг угааж ариутгаж болох боломж бүхий материалаар хийсэн байх ба тээвэрлэлтийн явцад ариун цэвэр эрүүл ахуйн нөхцөл хангагдсан байна.
- Мах махан бүтээгдэхүүнийг стандартын контейнер, хайрцаг сав, баглаа, боодолгүй, ил задгай болон өлгүүргүй, зориулалтын бус тээврийн хэрэгслэлээр тээвэрлэхийг хориглоно.
- Хөргөх төхөөрөмж, дулаан тусгаарлах дээвэр, хана, шал бүхий битүү бүхээг, тэвштэй тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн доторхи температур / гаднах дулаан +25С, +28С орчим байхад/ +2С, +4С ба хөлдөөж загсаасан бүтээгдэхүүн тээвэрлэх үед –2С, –4С байх шаардлагатай.
- Тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн нэмэгдэл төхөөрөмж, хэрэгслийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллана.